

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн “Алтай хотын тохижилт үйлчилгээний газар” ААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2022/08/-НА-СТА-ААТҮГ

Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2022 он	Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр Утас: 70483413 Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 70484055 Ахлах аудитор: Ж.Бүжинханд Утас: 99177546 Аудитор: Б.Цэвэлмаа Утас: 99026016	Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Цахим хаяг: Buujinkhandj@audit.gov.mn Цахим хаяг: Tsevelmaab@audit.gov.mn
---	---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	10
3.4 Материаллаг байдал.....	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	11
Байгууллагын үйл ажиллагаа	11
3.6 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	13
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	13
3.9.3 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилт	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
4. Аудитын илрүүлэлт.....	14
4.2.1 Залруулсан алдаа	14
4.2.2 Төлбөрийн акт	14
4.2.3 Албан шаардлага	15
4.2.4 Зөвлөмж.....	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.03.15 № 163

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Алтай хотын тохижилт үйлчилгээний газар” ААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол дагуу “Алтай хотын тохижилт үйлчилгээний газар” ААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Цалингийн урьдчилгаа дутуу суутгасан, төсвийн хэмнэлтийн горим зөрчиж шагнал олгосон, ажилчдын цалинг хувь хүний орлогын албан татварын тайланд дутуу тайлагнасан, санхүүгийн тайланд тооцоо нийлээгүй, 1-ээс дээш жилийн насжилттай авлага, өглөг бүртгэлтэй, татварын тодорхойлолтоор илүү, дутуу төлөлт татварын цахим системд бүртгэлтэй, нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, журмын дагуу хөтлөөгүй зэрэг 104.1 сая төгрөгийн зөрчлүүд нь Төсвийн тухай хууль, Засгийн газрын 43 дугаар тогтоол, Хувь хүний орлогын татварын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, АДБОУС 1250, 1300, MNS-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.4 заалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

“АЛТАЙ ХОТЫН ТОХИЖИЛТ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР” ААТҮГ-
ЫН ЗАХИРАЛ Ц.БАТ-ОРШИХ
ТАНАА

07020423


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБЯАР



2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	110,981,885.90	199,683,200.68
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	44,242,090.37	128,983,009.70
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	44,242,090.37	128,983,009.70
31210	Төгрөг	44,242,090.37	128,983,009.70
31213	Арилжааны банк дахь харилцах	44,242,090.37	128,983,009.70
33	АВЛАГА	2,536,799.55	38,966,319.64
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	2,096,409.75	1,663,819.95
33401	Дансны авлага /ТӨҮГ/	440,389.80	440,389.80
33500	Бусад авлага	0.00	36,862,109.89
33510	Байгууллагаас авах авлага	0.00	29,700,000.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	0.00	7,162,109.89
35	БАРАА МАТЕРИАЛ	64,202,995.98	31,733,871.34
35100	Түүхий эд материал	3,949,600.00	1,796,750.00
35110	Тусгай зориулалттай материал	3,949,600.00	1,796,750.00
35400	Хангамжийн материал	60,253,395.98	29,937,121.34
35410	Бичиг хэргийн материал	151,400.00	132,800.00
35420	Аж ахуйн материал	33,953,694.78	22,755,662.34
35430	Сэлбэг хэрэгсэл	1,831,000.00	2,893,000.00
35440	Түлш, шатах тослох материал	3,550,299.20	4,155,659.00
35450	Барилгын засварын материал	20,767,002.00	0.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	9,040,238,045.82	8,685,255,404.44
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	9,040,238,045.82	8,685,255,404.44
39200	Биет хөрөнгө	8,816,774,295.82	8,461,829,154.44
39201	Барилга, байгууламж, орон сууц	17,494,017.34	17,494,017.34
39202	Хуримтлагдсан элэгдэл	-10,910,740.29	-16,170,685.50
39203	Авто-тээврийн хэрэгсэл	702,353,600.00	719,653,600.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-321,751,644.46	-456,339,744.61
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	12,790,240.00	12,734,000.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-4,692,319.21	-7,826,222.61
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	6,032,581.00	6,032,581.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-2,044,862.71	-2,912,196.97
39209	Зам, гүүрийн байгууламж	10,958,287,926.10	9,584,843,940.08
39210	Хуримтлагдсан элэгдэл	-3,115,624,892.13	1,832,447,643.90
39214	Бусад үндсэн хөрөнгө	828,911,173.00	603,245,043.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-254,070,782.82	-166,477,533.39
39300	Биет бус хөрөнгө	223,463,750.00	223,426,250.00
39301	Програм хангамж	1,850,000.00	1,850,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,606,250.00	-1,643,750.00
39303	Бусад биет бус хөрөнгө	223,220,000.00	223,220,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	9,151,219,931.72	8,884,938,605.12
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	6,647,300.00	0.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	6,647,300.00	0.00
41300	Өглөг	6,647,300.00	0.00
41360	Бусад өглөг	6,647,300.00	0.00
41361	Байгууллагад төлөх өглөг	6,647,300.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	9,144,572,631.72	8,884,938,605.12
51	Засгийн газрын хувь оролцоо	9,144,572,631.72	8,884,938,605.12
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	4,540,074,518.29	4,540,074,518.29
51200	Хуримтлагдсан үр дүн	3,164,035,289.50	2,907,150,902.40

51210	Өмнөх үеийн үр дүн	2,706,212,989.83	3,151,133,866.50
51220	Тайлант үеийн үр дүн	457,822,299.67	-243,982,964.10
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,440,462,823.93	1,437,713,184.43
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	9,151,219,931.72	8,884,938,605.12

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,469,583,468.55	2,313,312,217.39
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,909,757,168.55	1,677,381,314.39
120	Нийтлэг татварын бус орлого	1,909,757,168.55	1,677,381,314.39
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,909,757,168.55	342,105,562.39
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	847,317.53	342,105,562.39
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,908,909,851.02	0.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	0.00	1,334,355,252.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	0.00	920,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	559,826,300.00	635,930,903.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	0.00	86,109,800.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	0.00	86,109,800.00
1330	Төсвийн захирагчдаас	559,826,300.00	549,821,103.00
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	559,826,300.00	549,821,103.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,898,933,909.72	2,190,021,079.46
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,898,933,909.72	2,190,021,079.46
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,898,933,909.72	2,181,655,879.46
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	279,888,253.79
210101	Үндсэн цалин	0.00	268,673,945.59
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	11,214,308.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	54,422,206.01
210201	Тэтгэврийн даатгал	0.00	54,422,206.01
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.00	4,727,618.04
210301	Гэрэл, цахилгаан	0.00	1,332,827.00
210302	Түлш, халаалт	0.00	1,835,691.04
210303	Цэвэр, бохир ус	0.00	1,559,100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	144,245,067.58
210401	Бичиг хэрэг	0.00	478,150.00
210402	Тээвэр, шатахуун	0.00	37,275,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	0.00	483,700.94
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	0.00	337,277.00
210408	Бараа материал акталсны зардал	0.00	37,097,767.04

210409	Бараа материал шилжүүлсний зардал	0.00	68,572,772.60
2105	Нормативт зардал	0.00	1,641,712.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0.00	224,000.00
210502	Хоол, хүнс	0.00	196,712.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00	1,221,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	1,909,600.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.00	990,600.00
210604	Урсгал засвар	0.00	919,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,898,933,909.72	388,408,693.20
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	346,138,750.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	0.00	60,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	0.00	495,500.00
210807	Газрын төлбөр	0.00	506,120.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	0.00	79,360.00
210811	Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/	14,157,608.16	15,018,785.00
210813	Бусад зардал /ТӨҮГ/	1,884,776,301.56	26,109,678.20
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	1,306,412,728.84
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	0.00	1,306,412,728.84
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	8,365,200.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	8,365,200.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0.00	4,749,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	1,500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	2,115,700.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	570,649,558.83	123,291,137.93
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	112,827,259.16	367,274,102.03
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	112,827,259.16	367,274,102.03
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	457,822,299.67	-243,982,964.10

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,540,074,518.29	1,440,462,823.93	3,164,035,289.50	9,144,572,631.72
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	4,540,074,518.29	1,440,462,823.93	3,164,035,289.50	9,144,572,631.72
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	-12,901,423.00	-12,901,423.00

13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,540,074,518.29	1,440,462,823.93	3,151,133,866.50	9,131,671,208.72
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	-2,749,639.50	0.00	-2,749,639.50
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
17	Өмчид гарсан өөрчилөлт	0.00	0.00	0.00	0.00
18	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-243,982,964.10	-243,982,964.10
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	4,540,074,518.29	1,437,713,184.43	2,907,150,902.40	8,884,938,605.12

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	568,914,817.53	978,036,465.39
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,441,217.53	342,105,562.39
120	Нийтлэг татварын бус орлого	2,441,217.53	342,105,562.39
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,441,217.53	342,105,562.39
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,441,217.53	342,105,562.39
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	566,473,600.00	635,930,903.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	0.00	86,109,800.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	0.00	86,109,800.00
1330	Төсвийн захирагчдаас	566,473,600.00	549,821,103.00
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	566,473,600.00	549,821,103.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	523,477,727.16	893,295,546.06
21	УРСГАЛ ЗАРДАЛ	523,477,727.16	893,295,546.06
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	523,477,727.16	884,968,346.06
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	256,320,836.00	269,458,916.78
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	10,879,308.20
210106	Ажилагчдад төлсөн /ТӨҮГ/	256,320,836.00	258,579,608.58
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,519,879.00	84,119,941.10

210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	36,519,879.00	84,119,941.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	72,699,750.00	4,727,618.04
210301	Гэрэл, цахилгаан	0.00	1,332,827.00
210302	Түлш, халаалт	0.00	1,835,691.04
210303	Цэвэр, бохир ус	0.00	1,440,800.00
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	72,699,750.00	118,300.00
2104	Хангамж, бараа материалын зардал	123,295,604.00	111,981,992.94
210401	Бичиг хэрэг	0.00	778,450.00
210402	Тээвэр, шатахуун	0.00	37,275,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	0.00	483,700.94
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө /ТӨҮГ/	97,619,354.00	42,000,195.00
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	25,676,250.00	31,444,247.00
2105	Нормативт зардал	0.00	1,641,712.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0.00	224,000.00
210502	Хоол, хүнс	0.00	196,712.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00	1,221,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	990,600.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.00	990,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	34,641,658.16	408,970,049.20
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	375,838,750.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	0.00	60,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	0.00	495,500.00
210807	Газрын төлбөр	0.00	506,120.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	0.00	79,360.00
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	956,980.00	25,342,519.20
210817	Даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	547,830.00	0.00
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	33,136,848.16	6,647,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	3,077,516.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	3,077,516.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	8,327,200.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	8,327,200.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0.00	4,749,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	1,500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	2,077,700.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	45,437,090.37	84,740,919.33

V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	1,195,000.00	0.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,195,000.00	0.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,195,000.00	0.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,195,000.00	0.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-1,195,000.00	0.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	44,242,090.37	84,740,919.33
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	44,242,090.37
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	44,242,090.37	128,983,009.70

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу "Алтай хотын тохижилт үйлчилгээний газар" ААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Цэвэлмаа гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

"Алтай хотын тохижилт үйлчилгээний газар" ААТҮГ нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 39 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй харин Монгол Улсын Засгийн газраас 43 дугаар тогтоолоор бүх шатны төсөв захирагч нарт төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажиллахыг даалгасан байна.

Тус газрын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

"Алтай хотын тохижилт үйлчилгээний газар" ААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,011.7 сая төгрөгөөс 2 хувиар буюу 20.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 13.0 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,011.7 сая төгрөгөөс 2 хувиар буюу 20.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 13.0 сая төгрөгөөр тогтоогдож байна.

Аудитын эрсдэл бага гэж үзэж тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-ын 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга Байгууллагын үйл ажиллагаа

“Алтай хотын тохижилт үйлчилгээний газар” ААТҮГ-ын улсын бүртгэлийн гэрчилгээнд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг аюулгүй хог хаягдлыг цуглуулах гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын статустай байна. Өмчийн 100 хувийг төр эзэмшиж байна.

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

“Алтай хотын тохижилт үйлчилгээний газар” нь 2006 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн шийдвэрээр байгуулагдсан байна.

“Алтай хотын тохижилт үйлчилгээний газар” ААТҮГ-ын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Улсын бүртгэлд үйл ажиллагааны чиглэлээ бүрэн зөв тодорхойлж бүртгүүлэх, орон нутгийн өмчит нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилт, автозам, гүүр, гадаргуугийн болон хөрсний ус зайлуулах барилга байгууламжийн цэвэрлэгээ, засвар үйлчилгээ, хотын гэрэлтүүлгийн засвар үйлчилгээ, энгийн хог хаягдлын менежментийг сайжруулах төсөл хэрэгжүүлэх, хэтийн төлөвийг тодорхойлох, их болон урсгал засварын нэгдсэн төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх, ашиглалтад хяналт тавих, төвлөрсөн хогийн цэгийн үйл ажиллагааг эрхлэх, нэгдсэн удирдлагаар хангах, өөрийн эзэмшлийн автомашин, механизм, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангах, үйл ажиллагааны чиглэлд тодорхойлсон үйл ажиллагааг бүрэн гүйцэд хэрэгжүүлэхэд оршино.

Есөнбулаг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн 38 дугаар тогтоолоор “Алтай хотын тохижилт үйлчилгээний газрын нэр, хэлбэрийг өөрчлөх тухай” аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар болгон статусыг өөрчилсөн байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3. “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж,

орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх,” заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй, шагнал урамшуулал олгосон, ажилчдын цалин хөлсийг нэмэгдүүлсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газраас 43 дугаар тогтоолоор бүх шатны төсөв захирагч нарт төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажиллахыг даалгажээ.

3.6 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

“Алтай хотын тохижилт үйлчилгээний газар” ААТҮГ-ын тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	44,242.09	128,983.01	84,740.92
Авлага	2,536.80	38,966.32	36,429.52
Бараа материал	64,203.00	31,733.87	(32,469.12)
Үндсэн хөрөнгө	9,040,238.05	8,685,255.40	(354,982.64)
Нийт хөрөнгийн дүн	9,151,219.93	8,884,938.61	(266,281.33)
Богино хугацаат өглөг	6,647.30	-	(6,647.30)
Эздийн өмч	9,144,572.63	8,884,938.61	(259,634.03)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	9,151,219.93	8,884,938.61	(266,281.33)

Банк дахь харилцах дансны үлдэгдэл 128.9 сая төгрөг байна.

Авлагын үлдэгдэлд шүүхийн шийдвэрээр олгосон цалингийн нөхөн олговрын 8.1 сая төгрөгийн, хувь хүмүүсээс авах авлага 1.2 сая төгрөг, байгууллагаас авах 29.7 сая төгрөг байна.

Авлагын үлдэгдэлд тооцоо нийлээгүй 9.2 сая төгрөгийн, нэгээс дээш жилийн насжилттай 2.5 сая төгрөгийн авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 31.7 сая төгрөг болж 32.5 сая төгрөгөөр буурсан нь 92.5 сая төгрөгийн бараа материалыг худалдан, 0.9 сая төгрөгийн материалыг хандиваар авч, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн шийдвэрээр 22.5 сая төгрөгийн бараа материалыг шилжүүлж, газрын даргын шийдвэрээр 14.6 сая төгрөгийн бараа материалыг акталж, 88.8 сая төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зарцуулснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь 17.3 сая төгрөгийн тээврийн хэрэгслийг шилжүүлэн авч, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн шийдвэрээр 9.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж, 2,924.2 сая төгрөгийн хөрөнгийн шилжүүлж данснаас хассантай холбоотой.

Богино хугацаат өр төлбөр данс үлдэгдэлгүй байна.

3.6 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу "Алтай хотын тохижилт үйлчилгээний газар" ААТҮГ нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Тайлант онд үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж батлуулаагүй байна.

Тус газар нь ААТҮГ-ын статустай боловч өөрийн орлого төвлөрүүлдэггүй, Есөнбулаг сумын ТТЗ-аас санхүүгийн дэмжлэг авч үйл ажиллагаагаа явуулж байна.

Гүйцэтгэлээр дээд шатны төсөв захирагчаас 549.8 сая төгрөгийн, сумын ОНХС-аас 86.1 сая төгрөгийн, ядуурлыг бууруулах Япон сангийн буцалтгүй тусламжаар хэрэгжих "Аймгийн төвийн хатуу хог хаягдлын менежментийн төслийн хүрээнд 340.8 сая төгрөгийн, бусад орлого 1.2 сая төгрөгийг төвлөрүүлж үйл ажиллагаандаа 549.8 сая төгрөгийн зарцуулсан байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу "Алтай хотын тохижилт үйлчилгээний газар" ААТҮГ-ны 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилт, худалдан авалтын и-баримт, худалдан авах ажиллагааг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

73 мэдээллээс мэдээллээс 36 мэдээллийг хугацаандаа, 36 мэдээллийг хугацаа хоцорч мэдээлсэн байна. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.9.2 Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилт

Тайлант онд 132.9 сая төгрөгийн и-баримтгүй худалдан авалт хийсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Татварын ерөнхий хуулийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад

дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ" гэсэн заалттай нийцээгүй байна.

3.9.3 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилт

Тайлант онд 51.8 сая төгрөгийн шатахууныг худалдан авах ажиллагаа зохион байгуулалгүй бэлтгэсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-т "Захиалагч бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа дор дурдсан тендер шалгаруулалтын журмыг баримтлан гүйцэтгэгчийг сонгож гэрээ байгуулна" гэсэн заалттай нийцээгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 6.6 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 5.5 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлснээс авлага барагдуулах, үйлдвэр санхүүжилтийн төлөвлөгөөг батлуулаагүй зөрчил арилаагүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авлага, өглөгийн барагдуулалт, нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, тээвэр шатахууны зарцуулал, төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажилласан эсэхийг авч үзэх нь зүйтэй. Мөн ядуурлыг бууруулах Япон сангийн буцалтгүй тусламжаар хэрэгжих "Аймгийн төвийн хатуу хог хаягдлын менежментийн төслийн хүрээнд хийгдсэн ажлыг данс бүртгэлд тусгасан эсэхийг үзэх шаардлагатай.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,211.0 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 922.2 сая төгрөгийн алдааг залруулж, 1.3 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 287.5 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүллээ.

4.2.1 Залруулсан алдаа

Авлагыг 38.2 сая төгрөгөөр, үндсэн хөрөнгийн тодруулгыг 829.1 сая төгрөгөөр, орлогыг 54.9 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг аудитын явцад байгууллагын удирдлага, нягтлан бодогч хүлээн зөвшөөрч санхүүгийн тайланд залруулав.

4.2.2 Төлбөрийн акт

Цалингийн урьдчилгаа 0.8 сая төгрөгийг дутуу суутгасан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай тогтоолыг баримтлалгүй ажилчдад 0.6 сая төгрөгийн шагнал олгосон нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар "Төсвийн

хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" тогтоолын 1.3-д "Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

4.2.3 Албан шаардлага

Зардлыг түүвэрлэн үзэхэд 132.9 сая төгрөгийн и-баримтгүй худалдан авалт хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ." гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Ажилчдын 28.5 сая төгрөгийн цалинг ХХОАТ-ын тайланд дутуу тайлагнасан нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1-д "Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого" гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Санхүүгийн тайланд 2.5 сая төгрөгийн тооцоо нийлээгүй, 1-ээс дээш жилийн насжилттай авлага бүртгэлтэй, барагдуулаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Татварын тодорхойлолтоор 1.7 сая төгрөгийн илүү, 63.2 сая төгрөгийн дутуу төлөлт татварын цахим системд бүртгэлтэй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.1-т "Аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 14.4.2-т "Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 14.4.3-т "Бүх өр төлбөр" гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Худалдан авах ажиллагаа зохион байгуулалгүй 51.8 сая төгрөгийн шатахуун бэлтгэсэн нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол

төсвөөс санхүүжилт гаргахыг хориглонод;" гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Эдийн засгийн зорилтот түвшнийг төлөвлөж батлуулаагүй, алдагдалтай ажилласан нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20.1.3-т "үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах"; гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай тогтоолыг баримтлалгүй ажилчдын үндсэн цалинг 40 хувиар нэмэгдүүлсэн нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" тогтоолын 1.3-д "Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;" гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, журмын дагуу хөтлөхгүй, шууд зардлаар тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө", 8.2-т "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана.", 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Ажлаас чөлөөлөгдсөн албан хаагчийн дуусгалтын тооцоог хийж, ээлжийн амралтын нөхөн олговрыг олгоогүй байгаа нь Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйл, Эрүүл мэндийн сайд, Нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 дугаар тушаалын 1 дүгээр зүйлийн 1.3-т "ажил олгогч нь бүх ажилтныг жил бүр ээлжийн амралтаа заавал биеэр эдлүүлэх бололцоогоор хангаж эдлүүлнэ", Хөдөлмөрийн тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1.2-т "Ажилтанд ээлжийн амралтын хугацаанд нь ээлжийн амралтын олговор олгоно" гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Төсвөөс 6.7 сая төгрөгийн цалингийн нөхөн олговор төлүүлж төсөв хохироосон нь Захиргааны ерөнхий хуулийн 103.1-т "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ.", Хөдөлмөрийн тухай хуулийн 132.1-т "Хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцдаа өөрийн буруугаас байгууллагад эд хөрөнгийн хохирол учруулсан ажилтанд сахилгын, захиргааны, эрүүгийн хариуцлага оногдуулсан эсэхийг харгалзахгүйгээр эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэнэ.", Төрийн албаны тухай хуулийн 50.1-т "Төрийн жинхэнэ албан хаагчийг хууль бусаар төрийн албанаас чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан

тушаалтнаар нөхөн төлүүлнэ гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний хөрөнгийн дүн санхүүгийн тайлан дахь төрийн өмчийн дүнгээс 18,612.2 сая төгрөгөөр зөрүүтэй байгаа нь Улсын бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр 14.2-т "Монгол Улсын иргэн, тус улсын нутаг дэвсгэрт оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээд энэ хуулийн 6, 7, 8 дугаар зүйлд заасан улсын бүртгэлийн мэдээллийг хуульд заасан хугацаанд улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэх үүрэгтэй.", Хууль зүй дотоод хэргийн сайдын 2018 оны А/208 дугаар тушаалаар баталсан "Хуулийн этгээд, түүний салбар, төлөөлөгчийн газрын улсын бүртгэл хөтлөх журам"-ын 8.2-т "Хуулийн этгээдийн дараах мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг хуульд өөрөөр заагаагүй бол ажлын 15 өдрийн дотор улсын бүртгэлд бүртгүүлнэ; 8.2.3-т "хувь нийлүүлсэн хөрөнгө;" гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

4.2.4 Зөвлөмж

Зөвлөмж өгөх алдаа зөрчилтэй асуудал илрээгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
	"Алтай хотын тохижилт үйлчилгээний газар" ААТҮГ	12	1,026.3	1	922.2	2	1.3	9	102.8		
Дүн		12	1,026.3	1	922.2	2	1.3	9	102.8		
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
	"Алтай хотын тохижилт үйлчилгээний газар" ААТҮГ	2	184.7					2	184.7		
Дүн		2	184.7					2	184.7		
Нийт дүн		14	1,211.0	1	922.2	2	1.3	11	287.5		